



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор сумын 5-р цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/61/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2020 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: М.Алтантуяа Утас:99061861 Цахим хаяг:</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.13. Шилэн дансны мэдээлэл	9
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж өгөгдөгүй болно.....	9
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....	10
3.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	10
3.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	11
3.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	12
3.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	14
3.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	14



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail: bayankhongor@audit.gov.mn

2020.02.27 № 1/2020

тантай _____ -ны № _____ -г

Г Аудитын гэрчилгээ Г

Г БАЯНХОНГОР СУМЫН 5 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ Э.ОЮУНТУЯА ТАНАА Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор сумын 5 дугаар цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянхонгор сумын 5 дугаар цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор сумын 5 дугаар цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\ 0030158


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

2.1. Оршил

Баянхонгор сумын 5-р цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Баянхонгор сумын 5-р цэцэрлэгийн эрхлэгч Э.Оюунтуяа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020.02.04-наас 2020.02.06-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020.02.27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор М.Алтантуяа хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор сумын 5-р цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2019.12.23-ны өдрийн 119 тоот бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Эрхэм зорилго: “Хүүхэд нэг бүрийг эрүүл биетэй саруул ухаантай сайн хүн болоход туслан хамтдаа хөгжинө.” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт ороогүй байна.

Баянхонгор сумын 5-р цэцэрлэгийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Баянхонгор сумын 5-р цэцэрлэгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянхонгор сумын 5-р цэцэрлэг нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Acoulas” программ хангамж ашигладаг байна.

Баянхонгор сумын 5-р цэцэрлэг нь төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 32 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 25 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Баянхонгор сумын 5-р цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр БСУГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “их” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 414699.2 мянган төгрөгөөс тооцон 8293.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 12675.6 мянган төгрөгөөр тооцсон.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянхонгор сумын 5-р цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 98078,7 мянган төгрөгөөр буюу 10,96 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материалын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	-
Авлага	-	2,359.5	2,359.5
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	71,054.5	61,260.9	(9,793.6)
Үндсэн хөрөнгө	881,681.9	883,906.7	2,224.8
Хуримтлагдсан элэгдэл	(57,272.6)	(150,142.0)	(92,869.4)
Нийт хөрөнгө	895,463.7	797,385.1	(98,078.7)
Өр төлбөр	96.1	-	(96.1)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	895,367.7	797,385.1	(97,982.6)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	895,463.7	797,385.1	(98,078.7)

Цэцэрлэгийн 2359,5 мянган төгрөгийн гадна гэрэлтүүлгийн ажил цэцэрлэгийн барилгын засварын ажил дуусаагүйтэй холбогдуулан тухайн ажил хийгдээгүйгээс авлагаар бүртгэж авлага өссөн.

Бараа материалын данс 9793,6 мянган төгрөгөөр буурсан нь 1488,7 мянган төгрөгийн аж ахуйн материал, тусгай зориулалтын материал 9066,6 мянга, мянга, бичиг хэргийн материал 214,0 мянга, бусад материал 629,1 мянган төгрөгөөр тус тус буурч, хүнсний материал 1604,8 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгө 2224,8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд хандивын хөрөнгөөр 3700,0 мянга, төсвийн хөрөнгөөр 1500,0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан ба Баянхонгор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 12-р сарын 25-ний өдрийн 129 дүгээр тогтоолын дагуу 2975,2 мянган төгрөгийн хөрөнгө акталсан байна.

Өр төлбөр 96,1 мянган төгрөгөөр буурсан, Засгийн газрын оролцоо данс тайлант үеийн үр дүнгийн өөрчлөлтөөр 97982,6 мянган төгрөгөөр буурсан байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант жилд 525048,8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 525022,9 мянган төгрөг зарцуулж 25,0 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн. Батлагдсан орон тоо 32 байхаас 34 орон тойгоор ажилласан. Үүнээс -2 орон тоо нь ээлжийн бүлгийн багш байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 6 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 25 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитаар дараах 4926,4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 2566,9 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 2359,5 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Хүүхдийн хоолны зардлыг нэг хүүхдэд ногдох дундаж нормативыг зөрчиж 962,2 мянга, хоолны зардлын төсвийн хэмнэлтээр худалдан авалт хийж тайлант хугацааны эцэст 1604,8 мянган төгрөгийн хүнсний материал нөөцөлж үлдэгдлээр тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2012 оны 106 дугаар тогтоолын 4-т "Нэг хүүхдэд ногдох дундаж нормативаар санхүүжүүлэх зардлын гүйцэтгэлийг хүүхэд өдрөөр хянаж зөрүүг тооцож байх" гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:Төлбөрийн акт тогтоов.

Тус байгууллага цэцэрлэгийн гадна гэрэлтүүлэг хийлгэх 2359,5 мянган төгрөгийн гэрээг 2019 оны 5-р сард "Би Би Ди Эм" ХХК- тай байгуулж урьдчилгаа төлбөрт 80 хувийг 5 сарын 22-нд 1887,6 мянга, үлдэгдэл 20 хувийг 12 дугаар сарын 24 нд 471,9 мянган төгрөгийг тус тус шилжүүлж, цэцэрлэгийн засварын ажил дуусаагүйтэй холбогдуулан тухайн ажил хийгдээгүйгээс авлагаар бүртгэн тайлагнасан нь Баянхонгор сумын засаг дарга Ж.Мөнхсоёл, эрхлэгч Э.Оюунтуяа, Би Би Ди Эм ХХК-ийн захирал Ц.Энхбаатар нарын гуравласан гэрээний ГЕН-ийн 1.4 т заасан "Гадна гэрэлтүүлгийн ажлыг 2019.07.01-нд хугацаанд нь хүлээлгэн өгнө", ТБОНӨХБАҮХА тухай хүүлийн 40-д заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:Албан шаардлага хүргүүлэв

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Тус цэцэрлэгийн эрхлэгчээр ажиллаж байсан Б.Ишмаад Баянхонгор аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2019 оны 02-р сарын 14 өдрийн 131/ШШ2019/00148 тоот захирамжаар 2017.09.21-2018.10.09 өдрийг хүртэлх хугацааны цалинг бүтнээр нь тооцож 11712101 төгрөгийг 2019 оны 9 сард олгосон. Б.Ишмаа нь 2017.09.21-2018.10.09 хугацаанд 12-р цэцэрлэгийн арга зүйчээр ажиллаж цалинг НДХ-т мэдээлж шимтгэлийг төлсөн, тухайн хугацаанд Төрийн байгууллагад ажил хөдөлмөр эрхэлж байсан тул энэ асуудлыг дахин нягталж хянах.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Баянхонгор сумын 5-р цэцэрлэг нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 145 мэдээллийг оруулахаас 113 мэдээллийг хугацаанд нь 32 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан хугацаа нь болоогүй 2 байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	6	8	8		
2	Хагас жил	1	1	1	-	-
3	Улирал бүр	1	4	3	1	-
4	Сар бүр	1	36	33	3	-
	Тухай бүр	7	96	68	28	-
	Нийт	16	145	113	32	

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж өгөгдөөгүй болно.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянхонгор сумын 5-р цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБООУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Бид Баянхонгор сумын 5-р цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНБООУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

3.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэ	Эцсийн үлдэгдэ
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	71,054,471.00	63,620,405.16
33	АВЛАГА	00.00	2,359,500.00
335	Бусад авлага	00.00	2,359,500.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	2,359,500.00
35	БАРАА МАТЕРИАЛ	71,054,471.00	61,260,905.16
351	Түүхий эд материал	38,933,625.00	29,867,043.16
35110	Тусгай зориулалттай материал	38,933,625.00	29,867,043.16
354	Хангамжийн материал	32,120,846.00	31,393,862.00
35410	Бичиг хэргийн материал	214,000.00	00.00
35420	Аж ахуйн материал	10,166,685.00	8,677,969.00
35460	Хүнсний материал	2,750,450.00	4,355,250.00
35470	Бусад хангамжийн материал	18,989,711.00	18,360,643.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	824,409,258.00	733,764,648.22
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	824,409,258.00	733,764,648.22
392	Биет хөрөнгө	674,758,841.41	584,314,648.22
39201	Барилга, байгууламж, орон сууц	637,800,131.00	637,800,131.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-24,990.00	-84,418,275.96
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	54,454,017.00	52,177,797.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-36,192,108.15	-39,990,165.64
39207	Тавилга, аж ахуйн эд хөгшил	20,840,996.28	23,466,996.28
39208	Хуримтлагдсан элэгдэл	-12,727,104.43	-14,337,596.63
39214	Бусад үндсэн хөрөнгө	17,892,024.15	20,092,024.15
39215	Хуримтлагдсан элэгдэл	-7,284,124.44	-10,476,261.98
393	Биет бус хөрөнгө	149,650,416.59	149,450,000.00
39301	Програм хангамж	1,244,720.00	919,720.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,044,303.41	-919,720.00
39303	Бусад биет бус хөрөнгө	149,450,000.00	149,450,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II	895,463,729.00	797,385,053.38
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	96,062.00	00.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	96,062.00	00.00
413	Өглөг	96,062.00	00.00
4136	Бусад өглөг	96,062.00	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	96,062.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	895,367,667.00	797,385,053.38
51	Засгийн газрын хувь оролцоо	895,367,667.00	797,385,053.38
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	457,736,119.00	457,736,119.00
51101	Өмч: - төрийн	457,736,119.00	457,736,119.00
512	Хуримтлагдсан үр дүн	-78,672,305.83	-176,654,919.45
51210	Өмнөх үеийн үр дүн	-78,672,305.83	-78,672,305.83
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-97,982,613.62
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	516,303,853.83	516,303,853.83
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	895,463,729.00	797,385,053.38

3.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	532,870,640.70	535,798,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	62,362,500.00	3,770,200.00
120	Нийтлэг татварын бус орлого	62,362,500.00	3,770,200.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	62,362,500.00	3,700,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	62,362,500.00	3,700,000.00
120009	Бусад орлого	00.00	70,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	9,879,940.70	100,005,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	460,628,200.00	432,021,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,083,906.70	6,979,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,083,906.70	6,979,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	93,026,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт	00.00	93,026,100.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	7,796,034.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	7,796,034.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	487,248,362.01	633,634,596.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	487,248,362.01	633,634,596.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	472,586,087.01	626,580,953.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	232,824,695.00	305,314,258.00
210101	Үндсэн цалин	208,690,455.00	256,670,758.00
210102	Нэмэгдэл	10,091,100.00	25,834,600.00
210104	Урамшуулал	14,043,140.00	22,808,900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,687,739.70	38,812,925.00
210201	Тэтгэврийн даатгал	24,873,484.00	27,476,145.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,887,691.70	3,112,833.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	111,500.00	2,670,668.00
210204	Ажилгүйдлийн даатгал	462,110.00	1,732,489.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,352,954.00	3,820,790.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	87,727,662.00	89,920,338.00
210301	Гэрэл, цахилгаан	7,751,953.00	8,587,409.00
210302	Түлш, халаалт	68,161,561.00	63,543,039.00
210303	Цэвэр, бохир ус	11,814,148.00	11,835,896.00
210304	Байрны түрээс	00.00	5,953,994.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,276,478.00	17,350,899.84
210401	Бичиг хэрэг	10,000.00	278,010.00
210402	Тээвэр, шатахуун	540,000.00	590,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	821,778.00	1,347,324.00
210404	Ном, хэвлэл	00.00	97,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	205,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	904,700.00	2,365,200.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	12,468,365.84
2105	Нормативт зардал	80,232,750.00	72,266,600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	151,400.00	31,950.00
210502	Хоол, хүнс	80,081,350.00	72,057,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	177,150.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	300,200.00	3,856,700.00
210604	Урсгал засвар	300,200.00	3,856,700.00
2107	Томилолт, зочны зардал	80,000.00	182,700.00
210702	Дотоод албан томилолт	80,000.00	182,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	740,100.00	1,147,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	740,100.00	897,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	250,000.00

Баянхонгор сумын 5-р цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39,716,462.31	97,729,532.91
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,557,534.00	284,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн даллага хийх	57,500.00	1,746,740.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	29,101,428.31	95,698,592.91
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,662,275.00	7,053,643.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,662,200.00	7,028,600.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	14,163,000.00	6,979,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	499,200.00	48,800.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	75.00	25,043.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	75.00	25,043.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	45,622,278.69	-97,836,596.75
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	186,365,010.11	146,016.87
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	69,458.61	146,016.87
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	186,295,551.50	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-186,365,010.11	-146,016.87
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-140,742,731.42	-97,982,613.62

3.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	470,508,140.70	537,476,705.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	70,200.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	70,200.00
120009	Бусад орлого	00.00	70,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	470,508,140.70	537,406,505.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	460,628,200.00	432,021,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,083,906.70	6,979,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,083,906.70	6,979,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	93,026,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	93,026,100.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	7,796,034.00	5,378,705.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	7,796,034.00	5,378,705.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	470,508,140.70	537,476,705.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	470,508,140.70	537,476,705.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	455,849,265.70	524,897,357.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	231,250,537.00	305,541,483.00
210101	Үндсэн цалин	207,227,637.00	256,897,983.00
210102	Нэмэгдэл	10,091,100.00	25,834,600.00
210104	Урам шуулал	13,931,800.00	22,808,900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,202,610.00	38,621,700.00
210201	Тэтгэврийн даатгал	22,256,546.00	26,988,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,163,700.00	2,908,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,967,300.00	2,326,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	462,110.00	581,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,352,954.00	5,816,800.00

Баянхонгор сумын 5-р цэцрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	87,721,900.00	90,226,100.00
210301	Гэрэл, цахилгаан	7,746,191.00	8,593,171.00
210302	Түлш, халаалт	68,161,561.00	63,843,039.00
210303	Цэвэр, бохир ус	11,814,148.00	11,835,896.00
210304	Байрны түрээс	00.00	5,953,994.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,723,678.00	4,798,574.00
210401	Бичиг хэрэг	176,200.00	279,050.00
210402	Тээвэр, шатахуун	540,000.00	590,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	821,778.00	1,347,324.00
210404	Ном, хэвлэл	108,000.00	97,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,077,700.00	2,305,200.00
2105	Нормативт зардал	83,115,400.00	74,631,400.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	91,400.00	91,950.00
210502	Хоол, хүнс	80,671,300.00	73,662,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,352,700.00	877,150.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,500,200.00	6,500,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,200,000.00	00.00
210604	Урсгал засвар	300,200.00	6,500,200.00
2107	Томилголт, зочны зардал	80,000.00	182,700.00
210702	Дотоод албан томилолт	80,000.00	182,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	693,800.00	1,143,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	693,800.00	943,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	200,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,561,140.70	3,251,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,446,140.70	70,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	115,000.00	3,181,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,658,875.00	12,579,348.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,658,800.00	12,554,305.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	00.00	5,378,705.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	14,163,000.00	6,979,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	495,800.00	195,800.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	75.00	25,043.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	75.00	25,043.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

3.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	308,286,119.00	00.00	62,070,425.59	370,356,544.59
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	308,286,119.00	00.00	62,070,425.59	370,356,544.59
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	149,450,000.00	00.00	-140,742,731.42	8,707,268.58
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	457,736,119.00	516,303,853.83	-78,672,305.83	895,367,667.00
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	457,736,119.00	516,303,853.83	-78,672,305.83	895,367,667.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	457,736,119.00	516,303,853.83	-78,672,305.83	895,367,667.00
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-97,982,613.62	-97,982,613.62
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	457,736,119.00	516,303,853.83	-176,654,919.45	797,385,053.38

3.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	525,048,000.00	525,022,957.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	525,048,000.00	525,022,957.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	524,852,200.00	524,827,157.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	305,565,400.00	305,541,483.00
210101	Үндсэн цалин	256,921,900.00	256,897,983.00
210102	Нэмэгдэл	25,834,600.00	25,834,600.00
210104	Урамшуулал	22,808,900.00	22,808,900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,621,700.00	38,621,700.00
210201	Тэтгэврийн даатгал	26,988,300.00	26,988,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,908,200.00	2,908,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,326,600.00	2,326,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	581,800.00	581,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,816,800.00	5,816,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	90,226,100.00	90,226,100.00
210301	Гэрэл, цахилгаан	7,698,600.00	8,593,171.00
210302	Түлш, халаалт	62,445,500.00	63,843,039.00
210303	Цэвэр, бохир ус	14,082,000.00	11,835,896.00
210304	Байрны түрээс	6,000,000.00	5,953,994.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,799,700.00	4,798,574.00
210401	Бичиг хэрэг	176,200.00	279,050.00
210402	Тээвэр, шатахуун	590,000.00	590,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,450,400.00	1,347,324.00
210404	Ном, хэвлэл	97,900.00	97,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	180,000.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,305,200.00	2,305,200.00

Баянхонгор сумын 5-р цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2105	Нормативт зардал	74,631,400.00	74,631,400.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	91,400.00	91,950.00
210502	Хоол, хүнс	73,662,300.00	73,662,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	877,700.00	877,150.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,500,200.00	6,500,200.00
210604	Урсгал засвар	6,500,200.00	6,500,200.00
2107	Томилолт, зочны зардал	182,700.00	182,700.00
210702	Дотоод албан томилолт	182,700.00	182,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамт	1,143,800.00	1,143,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийлэг ажил үйлчилгээний төлбөр	943,800.00	943,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000.00	200,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,181,200.00	3,181,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,181,200.00	3,181,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	195,800.00	195,800.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	195,800.00	195,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	195,800.00	195,800.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	525,048,000.00	525,022,957.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	432,021,900.00	431,996,857.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	432,021,900.00	431,996,857.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	93,026,100.00	93,026,100.00
132001	Орон нутгийн төсвөөс	93,026,100.00	93,026,100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	34.00	34.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	27.00	27.00
620003	Үйлчлэх ажилтан	06.00	06.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	260.00	260.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	34.00	34.00
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	19.00	19.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	15.00	15.00

3.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийг төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг

Дансны код	Үзүүлэлт	Баглагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		6,979,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		6,979,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	6979800.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		6,979,800.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		6,979,800.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	6979800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		6,979,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		6,979,800.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.00

САНХҮҮГИЙН ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР ХЯНАСАН АУДИТЫН МЕНЕЖЕР ТАЙЛАН БИЧСЭН АУДИТОР	 Б.МӨНХБАТ	ОГНОО: 2020.02.27
	А.ЦЭЭНЯМ	ОГНОО: 2020.02.27
	М.АЛТАНТУЯА	ОГНОО: 2020.02.27